



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 1/253

Ховд

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн тавдугаар хуралдааны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Хөшөөт хөгжил сангийн 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.19 дэх заалт Өвлийн жишиг хүлэмж Лөслийн оролцоо/ 100,000,000 төгрөг (нэг зуун сая)-ийн худалдан авах ажиллагаа зохион байгуулах, гэрээ байгуулах, тайлагнах эрхийг Жаргалант сумын Засаг дарга (Ц.Цогтбаяр)-д шилжүүлсүгэй.


2. Эрх шилжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулж 05 дугаар сарын 11-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээр хянуулан баталгаажуулсны үндсэн дээр, худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 20-ны дотор холбогдох хууль, журмын дагуу ил тод, нээлттэй, шуурхай зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулж, ашиглалтад хүлээн авах зэрэг хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, үр дүнг 08 дугаар сарын 30-ны дотор тайлагнахыг Жаргалант сумын Засаг дарга (Ц.Цогтбаяр)-д даалгасугай.

3. Эрх шилжүүлж буй хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д хариуцуулсугай.

8400 01 1284

4. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батсүх), өмч бүртгэлд тусгахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Ш.Нохойжав), холбогдох бичиг баримтын бүрдлийг хянаж санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.

ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ